



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/591

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нугийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 09/10 дугаар тогтоолоор батлагдсан Хархорин сумын 5 дугаар цэцэрлэгийн төсвийн урсгал засварын зардалд тусгагдсан 30 000 000 ( гучин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Хархорин сумын Засаг дарга (Л.Энхбат)-д, Бүрд сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн урсгал засварын зардалд тусгагдсан 30 000 000 (гучин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Бүрд сумын Засаг дарга (Г.Баярмөнх)-д тус тус шилжүүлсүгэй.

2. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын Газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101083